

ЯПОНЫ НОЁРХЛЫН ҮЕИЙН СОЛОНГОСЫН ХОЙГ, ТҮҮНИЙ ГАДААД ОРЧИН

Д. Уламбаяр*

I. 1910-аад оны Солонгосын хойг, түүний гадаад орчин:

Японы колоничлол эхэлснээс хойш Солонгосын ард түмэн, эх орончид дотооддоо ил болон нууц хэлбэрээр тууштэй тэмцэл явуулж байсан ба мөн ч олон мянган хүн баривчлагдан, харгислал амсч шорон гянданд хоригдон амь насаа алдаж байлаа. Мөн олон хүн эх орноосоо аргагүйн эрхэнд дүрвэн гарч байсан юм. Ард олны амьдрал ч тэсвэрлэшгүй байдалд хүрсэн нь мянга мянган хүнийг амь зуухын эрхэнд хилийн чанадад гарахад хүргэжээ.

1910 онд Япон Солонгосыг өөрийн нэг муж болгосон явдал нь тус бүс нутагт нөлөөгөө өргөтгөх гэсэн их гүрнүүдийн хоорондын зөрчлийг түр боловч намжаасан юм. 1914 онд Дэлхийн I дайн эхлэх үеэр Европын гүрнүүд Зүүн хойд Азиас түр хөндийрөхөд нээлттэй үлдсэн орон зайг ашиглан Япон улс эл бүс нутгийн олон улсын харилцааны чиг хандлагыг өөрчилж өргөжин тэлэх шинэ бодлогыг явуулж эхэлжээ. Энэхүү бодлого Японы түнш болох АНУ, Их Британи зэрэг их гүрнүүдийн ашиг сонирхлыг хааж байсан нь тодорхой юм. Япон улс болон тэдгээр орнуудын хоорондын зөрчилдөөн цаашдаа Зүүн хойд Азийн олон улсын харилцаанд хүчтэй нөлөөлсөн билээ. Их гүрнүүд Зүүн хойд Ази дахь бүс нутгийн зөрчлийг Солонгосын хойгтой холбосон нь “Солонгосын сургамж” гэсэн нэр томъёог гаргахад хүргэсэн ажээ.¹ Дипломатч Жон Н. Жордан Чусонь гүрний сүүлчийн улиралд Сөүлд Их Британий элчингээр сууж байхдаа Солонгост Япончуудыг нэвтрэн орж ирэхийг идэвхтэй дэмжиж байсан тэрээр 1914 онд Бээжинд мөн элчин байхдаа “Солонгосын сүүдэр Манжуур дээр тусаж байна” гэж сануулжээ. Жон Н. Жорданы үзэж байснаар

* МУИС, ОУХС-ийн ахлах багш, докторант

¹ Conroy F.H. *The Japanese seizure of Korea. 1868-1910; A Study of Realism and Idealism in Int'l Relations, Philadelphia. 1960, p.61*

Солонгос болон Манжуурт явуулж буй Японы бодлого нь өөрөөр хэлбэл Манжуур дахь төмөр замуудыг хянаж байсан Японы арга нь нөгөө л газар нутгаа тэлэх зорилготой байжээ. Мөн АНУ, Япон нь Солонгосыг эдийн засгийн ашиг сонирхлоо бэхжүүлэх үүднээс эзэлсэн, гэвч энэ нь сүүлдээ улс төрийн ноёрхол болон хувирсан, ерөнхийдөө Япон нь “урагшлах дипломат” бодлого явуулж байна. Хэрэв Хятад улс 1915 онд Японы тулган шаардах 21 зүйлийг зөвшөөрсөн бол улс төрийн болон эдийн засгийн хувьд бүрэн эрхт байдлаа алдан Солонгосын нэгэн адил Японы колоничлолд орох байсан гэж үзэж байв. Үүнээс үзэхэд Их гүрнүүд Солонгосыг нэгтгэснийг Японд зөвшөөрсөндөө харамсдаг болох нь харагддаг юм.

Эзлэн түрэмгийллийн дараа Япон улс Солонгосын хойг дээр цэрэг, армиа нэмэгдүүлэх стратегийн бодлого явуулсан билээ. Вацурагийн кабинетын баталсан 1911 оны Англи, Японы холбоотны гэрээний гуравдахь удаагийн засвар өөрчлөлтийг хянасан Саяонижи Кинмочигийн кабинет 1912 онд засгийн эрхийг авч Японы нийгэм-улс төрийн тогтолцоо, өмнөх энх тайван байдлыг хадгалах оролдлого хийжээ. Арми болон усан цэргийн хүч, батлан хамгаалалтыг хүчирхэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилтийг шаардсан юм. Учир нь 1907 оны эзэнт гүрний батлан хамгаалах бодлогод Орос улсыг үндэсний аюулгүй байдалд хамгийн их заналхийлэгч гэж үзээд дивизийн тоог өсгөх төлөвлөгөөг гаргасан ажээ. Энэхүү төлөвлөгөөн дэх Японы батлан хамгаалах эрх мэдлийн шаардлага нь олон нийтийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байв. Солонгос дахь шударга армийн эсэргүүцлийн хөдөлгөөн нурсан хийгээд батлан хамгаалах зардал өссөний эсрэг олон нийтийн эсэргүүцэлтэй бизнес болон боловсролын хүрээнийхэн нэгдсэнээр уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх явдал 1912 оноос хойш 2 жил хойшлогджээ. Эцэст нь уг төлөвлөгөө 1915 онд биеллээ олж, 1916 онд 19-р дивиз Оросын хилийн дэргэдэх Нанамд, 20-р дивиз 1919 оны 4-р сард Сөүлийн гадна орших Ёнсанд байрласан байна. Японы явуулсан хоёр дахь стратегийн бодлого нь Ялу мөрөн дээгүүр төмөр замын гүүр босгож түүнийгээ Аньдунаас Манжуурын гол хот болох Циньян руу чиглэсэн шинэ шугамтай холбож Манжуур руу орох Сөүл - Үйжүгийн төмөр замыг өргөтгөх явдал байв. Япончууд Ялу мөрний төмөр зам, гүүрийн төслийг 1909 онд эхэлж 2 жилийн богинохон хугацаанд гүйцээжээ. Ийнхүү Аньдун - Циньяны чиглэл бий болж Сөүл - Үйжүгийн шугамд холбогджээ. Японы энэхүү ажил нь Солонгост байрлах цэргийн тоогоо өсгөх явдлаас илүү шуудаар өөрсдий нь ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болох юм гэж үзэн уг бүс нутагт

явагдаж буй төмөр зам босгох ажлын үр нөлөө, үр дагаврыг ажиглах зорилгоор бүхий л дипломат ажиллагаагаа Зүүн хойд Азид төвлөрүүлжээ.

Солонгосын хойгт явуулж байсан Японы стратегийн бодлогын талаар их гүрнүүдийн хандлага 1911 оны Англи-Японы холбоотны гэрээний 3 дахь удаагийн шинэчлэлийн үеэрх маргаанд Солонгост хамаарах (гэрээний) нөхцөлд тусгалаа олжээ. Орос, Японы дайнд Япон ялах үед яригдаж байсан хоёр дахь Англи-Японы гэрээ нь 1905 онд баталгаажиж, 1915 онд шинэчлэгдэхээр төлөвлөгджээ.

Гэвч Солонгосыг эзэлсэн Японы байр суурийн улмаас үүдэн Зүүн Ази дахь улс төрийн өөрчлөгдсөн орчингоос шалтгаалан ялангуяа Япон, АНУ хоёрын хооронд гарч болох мөргөлдөөнийг Их Британи харгалзан, хэлэлцээ хийх хугацааг дөрвөн жилээр урагшлуулж 1911 онд Англи-Японы холбоотны 3 дахь гэрээнд гарын үсэг зурахад хүрчээ. Энэ гэрээ ёсоор Их Британи Хятадад явуулах Японы олон талт үйл ажиллагааг, ялангуяа Их Британийн ашиг сонирхолд харшлах үйл ажиллагааг хянах болжээ. Японы өргөжин тэлэхийг хязгаарлах Их Британийн байр суурь уг гэрээг хэрхэн засварлах тухай хэлэлцэх явцад Солонгост хамаатай гэрээний нөхцөлд сайн илэрхийлэгджээ.

Хоёр дахь Англи-Японы түншлэлийн гэрээгээр “Энэтхэгийн хилийн шугамын ойролцоо” тогтвортой байдлыг сахиулах “онцгой ашиг сонирхол”-ыг Их Британид зөвшөөрчээ. Япончууд энэ удаад тэдний хувьд шинэ хилийн шугам болоод байсан Солонгосын хойгт мөн тийм эрх олгохыг Их Британиас шаардсан юм. Гэсэн хэдий ч хилийн шугам дээр Их Британийн онцгой эрх эдлэх явдал нь цэвэр “батлан хамгаалах бодлого” байсан бол харин Солонгосын хойгийн хилийн шугам дээр онцгой эрх эдлэх Японы санаархал нь Манжуурыг эзлэн тэлэх холын бодлого байв. Иймд Их Британи Солонгост холбогдох гэрээний нөхцөлд Японы байр суурийг тодорхойлохдоо Өмнөд Манжуурын төмөр зам зэрэг Манжуур дахь өөрийн ашиг сонирхлоо Солонгос-Манжуурын хилийн бүс нутаг болгон өргөжүүлж шинэ улс төрийн ашиг сонирхол болгох оролдлого хайж байна гэж үзжээ. Их Британи гэрээний төсөл дэх Японы оруулсан нөхцлийг үгүйсгэж Японы шаардлагаас татгалзжээ.²

Ер нь 1910-аад оны үе нь Солонгос дахь Японы дэглэмийн эхний 10 жилийг хамардаг билээ. Эзэн хаантай харьцах хамгийн дээд эрх мэдэл бүхий Ерөнхий захирагчийн газрыг Сөүлд байгуулж, ингэснээр Японы үндсэн хуулиар хориглоогүй,

² Ian Hill Nish, *The Anglo-Japanese Alliance: The Diplomacy of Two Island Empires*, London., 1966, pp. 57-58

гэхдээ Японы эрх ашгийн төлөө, нэг талаар үр ашигтай, товч тодорхой шинэчлэлийн бодлого, нөгөө талаас Солонгосын ард түмний үндэсний онцлогийг устгах зорилготой уусган шингээх бодлого явуулжээ.

Их гүрнүүд энэхүү хөтөлбөрийг нь бүхэлдээ зөвшөөрөхгүй байсан боловч ялангуяа колоничлолын өмнөх Солонгосын үр ашиггүй хахуульд автсан Засгийн газрын бодлоготой Японы явуулж буй эл бодлогыг харьцуулан үзээд дэмжих хандлагатай байсан юм.

Тухайн үед Солонгос дахь Ерөнхий захирагч Тераючигийн засаглалын эсрэг Солонгосчуудын эсэргүүцлийг хүчээр дарж байлаа. Солонгос дахь Японы колоничлолын бодлогыг эерэгээр хүлцэж байсан их гүрнүүдийн байр суурь удаан үргэлжлээгүй ажээ. 1916 онд Тераючи Японы Ерөнхий сайд болоход Их Британи түүнийг улсаа төмөр гараар, Германы сахилгаар захирсан харгис хүн гэж тодорхойлжээ. Харин Тераючигийн залгамжлагчаар Солонгост томилогдсон Хасегава Ёшиличиг ил тод, шулуун, башир цэрэг байсан, Солонгосчуудын зүрхэнд айдас хуруулах чадварыг эзэмшсэн нэгэн гэж тодорхойлжээ.

1919 он гэхэд Ерөнхий захирагчийн газрыг харгис бурангуй Засгийн газар гэж ямар ч эргэлзээгүйгээр тодорхойлжээ.

Энэ үед Ерөнхий захирагчийн газрын ивээлээр дэвшиж буй материаллаг “хөгжил цэцэглэлтийг” үгүйсгээгүй их гүрнүүдийн байр суурь төдий л өөрчлөгдөөгүй ажээ. Гэвч Японы колоничлолын засаглал нь Солонгосчуудад хууль эрх зүйн хамгаалалтыг үзүүлэх, тэдэнтэй шударга ёсоор харьцах зэрэг ёс зүйн хүлээсэн үүргээ биелүүлээгүй юм. Энэ талаар их гүрнүүд хууль зүйн хэрэгжилтийг шаргуу шаардаж байв. Учир нь энэ асуудал тэдний шашны элч төлөөлөгчдийн үйл ажиллагаа, боловсролын төсөл гэх мэт эрх ямбыг хөндөж байлаа.

Их гүрнүүдийн ойлголтыг өөрчилсөн нэгэн үйл явдал бол Ерөнхий захирагчийн газрын тэргүүн Тераючийг хөнөөх гэсэн Солонгосын үндсэрхэг үзэлтнүүдийн оролдлого болох 1911 оны “105-ын хэрэг” юм. Энэ үйл явдлын талаар их гүрнүүд ашиг сонирхлоо илэрхийлэхдээ Солонгос үндэстнийг эзлэн түрэмгийлж буй Японы ноёрхолд бус, харин дараахи зүйлүүдэд илүү анхаарчээ.

Үүнд:

Нэгдүгээрт: уг хэрэгт оролцогчдын ихэнх нь христэд итгэгчид байсан ба элч төлөөлөгчид “missionaries” ч мөн оролцсон гэж Япончууд цуурхал тараасны улмаас христүүдийг баривчилж байгааг олон улс эсэргүүцэж байв.

Хоёрдугаарт: баривчлагсдыг хэрэгт хүчлэн тулгаж эрүүдсэн.

Гуравдугаарт: шүүх тэдэнд өөрийгөө өмгөөлөх, эсвэл хууль эрх зүйн хамгаалалт авахыг зөвшөөрөөгүй явдал байлаа.

Удалгүй олон нийтийн өмнө амлалт үүрэг авч Ерөнхий захирагчийн газар шударга хууль эрх зүйн тогтолцоог байгуулна гэж амлажээ.

Японд суугаа Их Британийн элчин сайд ноён Клауд МакДоналд Японы Гадаад хэргийн сайд Учида Ясуяад Сөүлд болсон шүүх хурал нь “шударга ёсыг гуйвуулсан” явдал болсон тухай шүүмжилжээ. Ноёрхлын үед шударга ёс, үнэн байдал Солонгост колоничлолын захиргааг удирдахад туйлын чухал болохыг МакДоналд Учидад нэлээд хэдэн удаа зөвлөж байжээ. Их гүрнүүд өөрсдийн элч төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдний эрх ямбыг устгах оролдлого хийж байна гэж үзэн дургүйцсэн юм. Япон болон их гүрнүүдийн хоорондох бүс нутгийн зөрчилдөөн болон үл итгэлцлийг эрчимжүүлсэн бас нэг зүйл нь Солонгосын хойгийн талаархи үзэл бодлыг нь шийдвэртэйгээр өөрчилсөн Японы эдийн засгийн бодлого байв.³

Уг нь өмнөх Солонгосын засгийн газрын тогтолцоог шинэчлэхэд чиглэсэн Ерөнхий захирагчийн газрын бодлогыг их гүрнүүд дэмжиж байсан билээ. Солонгосын эдийн засаг хөгжсөнөөр худалдааны “нэн таатай нөхцөл” бүрдэнэ гэж үзэн өөрийн эх орны компаниудыг Солонгост хөрөнгө оруулахыг зөвлөж байв. Гэвч их гүрнүүдийн энэ хүлээлт, найдлага нь эдийн засгийн асуудлыг авч хэлэлцсэн Ерөнхий захирагчийн газраас гаргасан олон хуулиудаас болж нуржээ. Эдгээр хуулиудын анхных нь 1911 оны эхээр хүчин төгөлдөр болсон Компанийн хууль байв. “Компанийн хууль” ёсоор шинэ компани байгуулах, салбар оффисуудаа нээх, бизнес эрхлэх зэрэгт Ерөнхий захирагчийн газрын зөвшөөрлийг авах ёстой байв. Амьдралд хэрэгжихдээ энэ хууль нь Солонгост үйл ажиллагааныхаа үндсийг тавихад нь гадаадын фирмд олон талаар саад болж байжээ.

Ингээд үр дүн нь Японы ноёрхлын эхний хэдхэн жилийн дотор их гүрнүүд Солонгосын хойгт өөрсдийн бараг бүх эрх ямбаа алдахад хүрсэн байна.

II. III сарын 1-ний хөдөлгөөн ба их гүрнүүдийн бодлого:

Колоничлолын бүхий л үеийн турш гарсан Солонгосын үндэсний эсэргүүцэх хөдөлгөөний хамгийн том нь 1919 оны 3-р сарын 1-ний /March First/ хөдөлгөөн юм.

³ Woonsang Choi. *The Diplomatic History of Korea*, Seoul, 1987 pp. 113-114

1919 оны 3-р сарын 1-ний хөдөлгөөн гарсан нь Зүүн хойд Азийн олон улсын харилцаанд 10 жилийн турш мартагдаад байсан Солонгосын асуудлыг их гүрнүүд дахин авч үзэхээс өөр аргагүй байдалд хүргэжээ. Түүнчлэн их гүрнүүд Солонгосын тусгаар тогтнолын асуудлыг дэлхийн I дайны төгсгөл үеэр хэлэлцэхдээ зөвхөн 3-р сарын 1-ний хөдөлгөөнөөр жагссан Солонгосчуудын зохион байгуулалтай тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг төдийгүй бас 1919 онд Шаньхайд байгуулагдсан Солонгосын Түр засгийн газрын тухай авч үзэх болсон явдал юм.

Энэ хөдөлгөөн Дэлхийн I дайны дараа Япон болон их гүрнүүдийн хоорондын харилцаа муудаж байсан үеийн ид дунд гарчээ. Дайны үед Япон нь Шаньдуны хойг дахь Цжиндао болон Өмнөд далайн арлуудыг эзэлчихсэн байснаас эдгээр газар нутгийн өмнөөс Парисын энх тайвны бага хуралд оролцох эрхтэй болсон байв. Гэлээ ч дайны дараа АНУ, Их Британи хоёр Зүүн Азид дахин идэвхтэй үйл ажиллагаа явуулж, эдгээр эзэмшлийг буцаахыг Японоос шаардаж байсан билээ. Дайны үеэр далд дипломатын бодлогоор олж авсан Шаньдуны хойгийг эзэмших эрхийг Хятадад буцаан өгөхийг, өөрөөр хэлбэл урьд өмнөх гэрээ хэлэлцээрийн дагуу бус, чөлөөт ардчилсан зарчмын үүднээс хандахыг В.Вильсон Японд зөвлөсөн ажээ. Дайны үед Холбоотнуудыг дэмжсэний хариуд Их Британи Парисын энх тайвны бага хурал дээр Японы байр суурийг дэмжихгүй байж чадаагүй ч дайны дараа өөрийн тэнгисийн хүчний дэлхийд тэргүүлэх байр суурийг алдахгүйг хичээн бас ч “сөрөг бодлогоо” хэрэгжүүлэхийг санаархаж байв. Мэдээж хэрэг дайны дараахи Зүүн Азийн дэг журмын талаар Япон болон их гүрнүүд бие биетэйгээ маш их зөрөлдөж байв. Үүнээс үүдэн Японд Америк, Английн эсрэг үзэл ид газар авч байх үед 3-р сарын 1-ний хөдөлгөөн гарчээ.

Энэ хөдөлгөөний талаар их гүрнүүдийн хандлага Японыхтой зөрчилдөж байсан ч эцсийн дүнд Солонгосыг дэмжиж байсандаа ч биш юм. Дэлхийн хамгийн том колони эзэмшигч гүрний хувьд Их Британи Солонгосын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг төдийлөн ойшоож үзээгүй нь энэхүү хөдөлгөөнийг амархан дарчихаж чадах Японы хувьд энэ нь түүний дотоод хэрэг гэж үзэж байсанд оршино. Гэлээ ч тэр үед Сөүл дэх Их Британийн Ерөнхий консулаар ажиллаж байсан Вильям Ройдс бусад дипломатуудын хамтаар 3-р сарын 1-ний хөдөлгөөний далд шалтгаан бол Японы уусган шингээх бодлого юм гэж үзэн энэ талаар нягт нарийн ажиглаж байв.

Энэ хөдөлгөөн дэх Солонгосчуудын зохион байгуулалт, нийгмийн дэг журмын төвшин, урьд өмнө байгаагүй тусгаар тогтнолын төлөөх тэмцлээс харвал Солонгосчууд “алгуур суларч доройтохын оронд орон нутгийн өөртөө захирах засгийн газрыг өргөжих”-ийг илүүд үзэж байна гэж Ройдс үзжээ. Гэсэн хэдий ч Лондон дахь Их Британийн Гадаад хэргийн яам Энэтхэг болон бусад колонийн орнууд дахь Британийн бодлоготой харьцуулахад Японы бодлогод “төгс хариулт” болсон гэж энэ хөдөлгөөнийг дорвитой ойшоогоогүй юм.

Харин Чеам-ри дахь Японы цэргийн аллагын тухай мэдээ 5-р сарын эхээр Лондонд ирэхэд Британичууд Солонгосын байдлыг тухайлан сонирхож эхэлжээ. Япон дахь Британий элчин сайд Бэйлби Ф.Алстон, Японы Гадаад хэргийн туслах нарийн бичгийн дарга Шидехара Кижёд эсэргүүцэл илэрхийлжээ. Ф.Алстон “Японы бусармаг үйлдэлд соёлжсон ертөнц аягүйцэж байгааг” Лондон дахь Японы элчин сайдад мөн мэдэгдэх талаар Гадаад хэргийн яамнаасаа шаарджээ. Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан ГХЯ Солонгосын асуудлаар өргөн хүрээний судалгаа санаачлан хийж “Солонгос дахь Японы явуулж буй бодлого” гэж нэрлэгдсэн меморандумд Алс Дорнодын газрын тэргүүн Ж.В.Макс Мюллер “Солонгосыг японжуулах Японы бодлого”-ын байр суурийг тодорхойлжээ.⁴

Их Британи Солонгосын тусгаар тогтнолын асуудалд оролцохоос зайлсхийх хэрэгтэйг анхааруулаад Ж.В.Макс Мюллер уг асуудлыг шийдвэрлэхдээ эцсийн зам бол Япон Солонгост өөртөө засаглах зарим хэлбэрийг олгох, уусган шингээх бодлогоосоо татгалзах, солонгос хэлний боловсролыг дэмжих зэрэг арга хэмжээг авч явуулах ёстой гэж шаарджээ.

Их Британийн Гадаад хэргийн орлогч сайд, лордын танхимын гишүүн Жорж Крузон, Японы элчин сайд Чинда Сүшемитай 7-р сард 2 удаа уулзсан ба Японы эзлэн түрэмгийлэх бодлогыг тун товч бөгөөд тодорхой шүүмжилж Япон нь Ж.В.Макс Мюллерийн меморандумд тусгасан шинэчлэлүүдийг хийх нь зүйтэй гэж зөвлөсөн байна.

Байдлыг сайжруулахад чиглэсэн алхмуудыг Адмирал Сайто Макото Ерөнхий захирагчаар томилогдоод 8-р сард эхлэн явуулсан боловч эдгээр арга хэмжээ нь бодитой шинэчлэлийг авчраагүй юм. Их Британи энэхүү ажиллагаанд нь зэвүүцлээ илэрхийлж, Ерөнхий захирагчийн газар хэрэв хүссэн бол Японы энэхүү бусармаг үйлдлийг үзэг хөдөлгөөд л зогсоож чадах байсан гэж үзэж байв. Их Британийн

⁴ Ian Hill Nish, *The Anglo-Japanese Alliance: The Diplomacy of Two Island Empires*, London., 1966, pp. 65-66

дипломатчид энэхүү асуудлыг Японы эрх мэдэлтнүүдтэй харилцах харилцаандаа гол асуудал болгож байлаа. Харин 1920-иод оны эхээр тэд өөрсдийн эсэргүүцлээ тийм ч сайн үр дүнд хүрсэнгүй гэж дүгнээд уг асуудалд хөндлөнгөөс оролцохоо больжээ. Их Британи өөртөө удирдах засгийн газрыг дэмжих болон уусган шингээх бодлогоо зогсоох зэрэг улс төрийн асуудлуудыг гарган тавьж байсан урьдын аргаасаа ухарч, Солонгосын асуудалд цэвэр хүний эрхтэй холбогдох дипломат бодлогоор өөрчлөх янзтай болсон юм.

АНУ-ын 3-р сарын 1-ний хөдөлгөөнд хандах хандлага нь Их Британийхаас илүү булзамхай буюу яах гээд байгаа нь мэдэгдэхгүй байв. Учир нь Филиппинийн эсрэг Япон цэргийн ажиллагаа явуулахаас татгалзсаны хариуд АНУ Солонгос дахь Японы протекторатыг хүлээн зөвшөөрсөн АНУ, Японы 1905 оны 7-р сарын 27-ны нууц хэлэлцээртэй энэ нь олон талаар холбоотой байв.

Дэлхийн I дайн эхэлснээр Зүүн Азийн олон улсын байдал Япон-Нэгдсэн Улс хоёрын хоорондын зөрчилдөөний талбар хэвээрээ байв. Хоёр улсын хоорондын харилцаа дайны төгсгөл үед туйлын хурцадсан нь Японы <<дотоод асуудал>> болсон Солонгосын үйл хэрэгт Нэгдсэн Улс оролцох зай өгөөгүй явдал юм. АНУ энэ хөдөлгөөнд оролцогчдын ихэнх нь өөрсдийн шашны элч болон бусад иргэд байсан гэж үзсэн Японы хандлагыг дангаараа энэ нь хоёр улсын харилцааг улам дордуулах хангалттай хүчин зүйл болно гэж үзэж байв.

Тусгаар тогтнолын төлөөх тэмцэлд оролцсон Солонгосчууд Нэгдсэн Улсыг тэдний тусгаар тогтнолыг дэмжих цорын ганц их гүрэн, тэгээд ч “улс үндэстний өөртөө засан тогтнох эрхийн номлолыг” гаргасан гүрний хувьд тууштай хүлээн авчээ. Тусгаар тогтнолын төлөө эх орондоо болон хилийн чанадад ажиллаж байсан Солонгосын удирдагчид үйл ажиллагаагаа шууд болон шууд бусаар Нэгдсэн Улстай уялдуулан явуулахад чиглүүлж байв. Харин Нэгдсэн Улсын засгийн газар Солонгосын асуудалд идэвхгүй хандаж байлаа.

1918 оны 1-р сард дэвшүүлсэн Ерөнхийлөгч Вудро Вильсоны 14 зүйлт Тунхаглал⁵ буюу улс үндэстний өөртөө засан тогтнох эрхийн номлолын дагуу хилийн чанад дахь Солонгосын дэвшилт зүтгэлтнүүд Парис руу өөрийн төлөөлөгчдийг явуулахаар тогтжээ. Үүнд: Шанхайгаас Ким Гюү-шиг⁶, Жиан Дао

⁵ Howard K. Beale. *Woodrow Wilson and the Rise of to World Power*. Baltimore, 1966, p. 81

⁶ Ким Гюү шиг (1881-1950) Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, 1919 онд Шанхайд байгуулагдсан Солонгосын түр засгийн газрын Гадаад хэргийн сайд, Солонгосын Хувьсгалт намын дарга, 1897 онд Америк явж Лунгоок коллеж дүүргэж, 1904 онд Принстоны их сургуулийг магистр

болон Сибирийн Никольскоос Юнь Хэе, Ко Жан-Ил, АНУ-аас Ий Сүн-мань⁷, Хэнри Чань (Чон Хань Гён) нарыг явуулахаар болжээ. АНУ дахь Солонгос-Америкийн холбооноос Ий болон Чань нарыг явуулах оролдлого нь АНУ-ын эсэргүүцэлтэй тулгарч “Солонгосын асуудал нь I дайнтай холбоотой асуудал” биш гэж үзэн тэдний паспортыг гаргаагүйгээс болж Энх тайвны бага хуралд Солонгосчууд өөрсдийн дуу хоолойгоо хүргэж чадаагүй байна.

Энх тайвны Нобелийн шагнал хүртсэн В.Вильсон тэрээр улс үндэстнүүдийн өөртөө засан тогтнох эрхийг амьдрал дээр хэрэгжүүлэхийг хичээж байсан ч дайны дараах асуудлуудыг шийдвэрлэх явцад үндэстэн ба колонийн асуудалд хариу олох нь тийм ч амар биш, хэцүү болохыг ухаарчээ. Бусад гүрнүүд болох Их Британи, Франц, Япон улс Парисын бага хурал дээр колонийн асуудлыг авч хэлэлцэхийг хүсэхгүй байсан юм. Улс үндэстний өөртөө засан тогтнох номлолыг ямар ч үндэстнийг үл ялгаварлан хэрэгжүүлснээр 50 гаруй улсын хилийг өөрчлөхөд хүргэж, ингэснээр энэ нь найрамдлыг тогтворжуулах хүчин зүйл бус, харин дэлхийн энх тайванд учирч болох аюул мэтээр тодорхойлогдож байв. Иймд АНУ уг номлолыг чанд баримтлах бодлогоо орхисон байна. АНУ-ын энэ алхамтай холбогдоод Солонгос дахь байдал сайжирсангүй. 1918 оны сүүлээр Сөүл болон Токио дахь АНУ-ын эрх мэдэлтнүүд В.Вильсоны улс үндэстнүүд өөртөө засан тогтнох зарчмыг дэмжсэн эрмэлзэл нь Солонгосын хойгт үймээн самуун гарахаас болгоомжлоход хүргэжээ. Сөүл дэх АНУ-ын Ерөнхий консул Лео А.Бергхольз Японы эсрэг Солонгосчуудын хөдөлгөөн улам бүр хүчээ авч эзэн хаан Кужоныг нас барснаас хойш “хаант засагтаа үнэнч сэтгэлгээг сэргээж” болохыг тэмдэглээд уг хөдөлгөөн нь ноцтой зөрчилд хүргэж болохыг дурджээ. Л.А.Бергхольз цаашлаад Солонгосчуудыг далдуур өдөөн хатгаж байгаа гэгдэн сэжиглэгдэж буй өөрсдийн шашны элч төлөөлөгч нартаа Солонгосын улс төрийн хэрэгт хөндлөнгөөс үл оролцохыг урьдчилан сануулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзсэн байна. Урьд нь албан ёсоор 1897 оны 1-р сарын 18-нд нийтлэгдсэн анхааруулгыг Сөүл дэх АНУ-ын элчин Жон М.В.Силл элч төлөөлөгч нартаа “улс орны дотоод хэрэгт оролцохоос ёсорхоогоор түтгэлзэж зайлсхийх” бодлогыг дагаж

зэрэгтэй төгсчээ. 1918 онд Америкийн <<Андерсон энд Мейер ко>> нүүсийн Нийслэл Хүрэн дэх салбарт ажиллаж байгаад Францаар дамжин Америк явжээ. 1922 оны 1-р сард На Юн Гюнь, Ёо Унь Хён нарын хамт Нийслэл Хүрээгээр дамжин Москва явж, Дорно дахины хөдөлмөрчдийн их хуралд оролцож байв.

⁷ Ий Сүн мань (1875-1965) Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөний гарамгай зүтгэлтэн, БНСУ-ын анхны ерөнхийлөгч, 1905-1907 онд Жорж Вашингтоны их сургуульд элсэн орж төгсөөд 1908 онд Харвардын их сургуулийн магистр, 1910 онд Принстоны их сургуулийн доктор болсон нь АНУ-д доктор хамгаалсан анхны солонгос байв.

мөрдөхийг шаардаж байжээ. 3-р сарын 1-ний хөдөлгөөн гарсантай холбогдуулан Японы Ерөнхий захирагчийн газар, АНУ-ын элч төлөөлөгч нарын хоорондын хурцадмал байдлыг авч үзээд АНУ-ын Төрийн Департамент болон Сөүл дэх АНУ-ын эрх мэдэлтнүүдэд Солонгосын нөхцөл байдалд дээд зэргийн болгоомжтой хандаж төвийг сахихыг шаардсан байна.⁸

Тэдний төлөвлөгөөг АНУ дэмжиж туслах болно гэсэн найдварыг Солонгосын <<үндсэрхэг үзэлтнүүдэд>> төрүүлэхгүй байх, мөн Солонгосын үндэсний хөдөлгөөнтэй АНУ-ын Засгийн газрыг холбогдуулан сэжиглэх үндэслэлийг Японы эрх баригчдад төрүүлэхгүй байх талаар “туйлын анхаарал болгоомжтой” ажиллахыг Төрийн Департамент онцлон анхааруулжээ. Энэ нь Солонгосын асуудлаар явуулах АНУ-ын бодлогын эцсийн хувилбар болсон юм. Түүнчлэн Японы түнш болох Их Британид Солонгосын асуудалд хөндлөнгөөс оролцох ямар ч ашиг сонирхол байхгүйгээ АНУ албан ёсоор илэрхийлжээ.

Харин Вашингтонд АНУ болон Японы дипломатчдын уулзалтан дээр Солонгосын асуудал нэг удаа сөхөгджээ. Гэхдээ энэ нь Шаньдунын хойгийн асуудлаас болж Америкийн нийгэмд Японын эсрэг үзэл газар авч буйд санаа зовж байгаагаа Японы хэргийг түр хамаарагчид Алс дорнодын хэрэг эрхлэх газрын албаны хүмүүс зөвлөлдөх үеэрээ хэлжээ. Хэдийгээр АНУ-ын Засгийн газар асуудлыг идэвхгүй хөндсөн ч гэсэн Солонгосын тусгаар тогтнох хөдөлгөөний талынхан АНУ-ын олон нийтийн санааг татсанаараа харьцангуй амжилттай болсон гэж үзжээ.

1919 оны 4-р сарын 14-нөөс 16-нд Феладелфид Со Чэ Пил⁹ (Филип Жейсон), Ий Сүн-мань, Хэнри Чань болон бусад удирдагчид анхны “Солонгосын Конгресс”-ийг хуралдуулж бизнесийн хүрээнийхэн, боловсрол, шашны нийгэмлэг, тэр ч байтугай хэвлэл мэдээллийн салбаруудаас америкчуудыг урьж оролцуулсан байна. Уг уулзалт тэдэнд Солонгос дахь тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний бодит байдлыг тайлбарлан Японы эзлэн түрэмгийлэгчдийг эрс шүүмжлэн мэдэгдэх боломж олгосон юм.

Конгрессын сүүлчийн өдөр Ий Сүн-мань тусгаар тогтнолын талбай тийш жагсагчдыг удирдан явж тусгаар тогтнолын тунхаглалыг уншиж байжээ. Со Чэ Пил

⁸ Frank P. Baldwin. *The March First Movement: Korean Challenge and Japanese Response*. Columbia University. 1969, p. 132

⁹ Со Чэ Пил (Филип Жейсон) доктор (1866-1951), тусгаар тогтнолын клубыг үндэслэгч, Сөүлд сонгодог хятад хэл бичгийн сургууль, Токиод армийн сургуульд суралцаж ахлах офицер болсон. 1895 онд АНУ-ын Жоржс Вашингтоны их сургуулийн анагаах ухааны салбарыг төгссөн анхны солонгос эмч болно. “Тусгаар тогтнол” сонинны үндэслэгч бөгөөд эрхлэгч нь байв.

болон бусад удирдагчид АНУ дахь олон нийтийн анхаарлыг Солонгосын асуудалд хандуулахад идэвхтэй ажиллаж “Солонгосын нөхөд” байгууллагыг байгуулж, түүний үр дүнд Нэгдсэн улсад 17 салбар бий болсон байна. Энэ бүх хичээл зүтгэлийн үр дүнд Солонгосын асуудал АНУ-ын гол гол сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байнга хөндөгдөх болсон ажээ. Гэхдээ АНУ дахь Солонгосын тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөний удирдагчдын энэхүү амжилтын учиг шалтгаан нь Версалийн гэрээ болон Үндэстнүүдийн Холбоог буй болгохын эсрэг сөрөг хүчин нэмэгдсэн, Шаньдуны хойгийн асуудлаас урган гарсан АНУ дахь Японы эсрэг үзэл хүчтэй хэвээр байснаар тайлбарлагдана. Энэ нөхцөл байдал Японы эзлэн түрэмгийлэл Ази тивээр зогсохгүй цаашлаад АНУ руу өөр лүү нь чиглэх болно гэж Солонгосын удирдагчид үзэж байв.

Гэвч 1919 оны 6-р сард болсон Парисын Энх тайвны бага хурал Солонгосын байдлыг авч хэлэлцэлгүйгээр өндөрлөсөн нь <<Солонгосын асуудлыг>> олон улсын асуудал болгох ганц боломж нь тухайн үед зөвхөн Үндэстнүүдийн Холбоонд хандсанаар шийдвэрлэгдэж болох гарц байв.

Үүний тулд Их Британи зэрэг Европын их гүрнүүдэн бус, харин сул буурай ард түмний тусгаар тогтнолыг дэмжсэн АНУ-ын дэмжлэгийг авах нь чухал байсан юм. Ийм зорилгоор Солонгосын хөдөлгөөнийхөн Версалийн гэрээг соёрхон батлахыг болон Үндэстнүүдийн Холбоонд АНУ-ыг орохыг дэмжих хэрэгтэй байв. Нөгөө талаар Версалийн гэрээ ба Үндэстнүүдийн Холбоог эсэргүүцэх хөдөлгөөн ч гарсан юм. Тэд империалистуудын эсрэг шинжийг агуулж байснаараа бусад дарлагдсан улс түмний дэмжлэгийг олж авахыг зорьж байв. Яах аргагүй байдалд орсон Солонгосын хөдөлгөөнийхөн Үндэстнүүдийн Холбоогоор дамжуулан тусгаар тогтнолоо олж авах гэсэн хэтийн зорилгоосоо түдгэлзэн Японы эсрэг хөдөлгөөнд өөрсдөө шууд татагдан оролцох болсон байна.

III. 1920-иод оны Солонгосын хойг дахь олон улсын харилцаа:

АНУ-ын удирдлага дор бүрэлдэн бий болсон 1922 оны Вашингтоны системийн нөлөөгөөр 1920-иод оны дунд үе хүртэл Зүүн Ази нь харьцангуй тогтвортой байв. Гэхдээ амьдрал дээр энэ систем нь тодорхой хязгаарлалтай байсан юм. 1920-иод оны үед Солонгос дахь ерөнхий захирагч Сайто Макото, түүний “соёлын бодлого” гэгч нь түүний өмнөх удирдагчид болох Тераючи, Хасегава нарын цэрэг, зэвсгийн бодлогоос харьцангуй аядуу байжээ.

Сайто Солонгосын улс төрийн байллыг соёлын бодлогоороо тогтворжуулж, Ерөнхий захирагчийн газар болон барууныхантай (элч төлөөлөгчдийг хамруулан) харилцаагаа сайжруулж, Япон болон их гүрнүүдийн үзэж байснаар тэрбээр цаг үеийнхээ хамгийн шилдэг Ерөнхий захирагч байсан ажээ.

1929 онд Сайтог хоёр дахь удаагаа Ерөнхий захирагчаар томилогдоход Солонгосчууд үнэндээ түүнд дуртай биш байв. Учир нь тэдэнд Сайтогийн талаар гомдоллох шалтаг байгаагүй ажээ. Өөрөөр хэлбэл Сайто тэдэнд юу хүссэнийг нь өгч байсан юм гэж Бриатнийн хэвлэлд ёжтойхон нийтлэжээ. Харин Нэгдсэн улс 6-р сарын 10-ны хэрэг явдал (1926 онд Сунжоны оршуулгын өдөр болсон) нь Сайтогийн чөлөөт бодлого, түүний бүх анги давхаргын итгэл хүндэтгэлийг хүлээсэн зэргээс 3-р сарын 1-ний хөдөлгөөн шиг ноцтой явдал болоогүй өнгөрчээ.

Солонгосчууд өөрсдөө энэхүү гадны удирдагчийг <<өргөн магтаж>> байсан нь хэрэг дээрээ өөр шалтгаантай байсан ажээ. Сөүл дэх АНУ-ын Ерөнхий консул Рамсфорд Миллер 1929 онд Вашингтонд илтгэхдээ: Солонгосчууд Сайтогийн хоёр дахиа томилогдсон явдалд ямар ч нөлөө үзүүлээгүй, учир нь тэдний хувьд Ерөнхий захирагч хэн байх нь хамаагүй. Хэдийгээр Сайтогийн хоёр дахь удаагийн томилогдсон хугацаанд удирдагч, удирдуулагчийн хоорондын харилцаанд ямар ч өөрчлөлт гараагүй ч тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөн зогсоогүй юм. Өөрийн бодлогоо зөвтгөх, хэрэгжүүлэхийн тулд Сайтосан ямар ч арга бодлого явууллаа ч тэр нь Солонгос дахь Японы ноёрхлыг сулруулахад чиглэгдэхгүй гэдгийг л солонгосчууд сайн мэдэж байсанд оршино гэжээ. Үнэхээр ч тийм байсан билээ.

IV. Солонгосын талаарх Зөвлөлт засгийн хоёр нүүрт бодлого:

Коммунист үзэл санааны тархалт Солонгосын улс төрийн амьдралд 1920-иод онд гарч ирсэн нь шинэ үзэгдэл бөгөөд асуудал байв. 1918 оноос хойш В.И.Ленин Дорно дахины дарлагдсан хөдөлмөрчдийн өөртөө засан тогтнох эрхийн тухай, үндэстэн ба колонийн асуудлаар цогтой дуугарах болж орчин үеийн хувьсгал дахь Дорно дахины сэргэлтийн үеийн дараа тэдгээр ард түмэн зөвхөн баяжуулагч, түүхий эд нийлүүлэгч байхаа больж дэлхийн хувь заяаг шийдвэрлэхэд оролцох үе эхэлж байна гэж үзэж байв. Өрнөдийн капитализмыг буулгаж авахад тэдний колони дорно дахины орнуудад большевизмыг түгээн дэлгэрүүлэх явдал байсан юм. В.И.Ленин социалист төрийн гадаад улс төрийн бодлого, дипломат ажиллагааны үндсийг тавихын хамт Хаант болон Түр засгийн газраас бусад орнуудтай урьд өмнө

байгуулсан бүх нууц гэрээ, хэлэлцээрийг хүчингүй болгосноо зарлажээ. Үүгээр Солонгос, Монгол, Хятадтай холбоотой нууц гэрээнүүд ил болсон билээ. **“Тусгай эрх ашиг”, “нөлөөний хүрээ”** зэрэг нэр томъёо олон улсын харилцааны үг хэллэгт шинээр орж ирснийг эдгээр нууц гэрээ протоколуудаас харж болох ажээ.

3-р сарын 1-ний хөдөлгөөний бүтэлгүйтэл, Солонгосын асуудал Парисын болон Вашингтоны бага хурлын аль алин дээр нь хөндөгдөөгүй нь солонгосчуудыг шинээр буй болсон Зөвлөлт Орост хандахад хүргэжээ. Шанхайд 1919 оны 3-р сарын 20-нд Солонгосын тусгаар тогтнолыг тунгхагласны дараахан Зөвлөлт засгийн газар Солонгосын ард түмэн, хувьсгалт байгууллагуудад хандаж Японы эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг хамтран тэмцэх тухай уриалга гаргажээ. Уриалгад өгүүлэхдээ: **“Владивосток болон Өглөөний амгалангийн орноос (Чусонь) япончуудыг бид зөвхөн нэгдсэн чармайлтаар хүчээр хөөн гаргаж чадна”**¹⁰ гэжээ.

Улаан Орос өөрийн суртал ухуулгадаа Солонгосын асуудлыг онцгойлон анхаарч тэднийг дэмжих санал тавьж байлаа. Солонгост хувьсгал өрнүүлэх зорилготой Зөвлөлтийн суртал нэвтрүүлэг 1919 оны 6-р сард Гадаад хэргийн ардын комиссарын орлогч Лев Караханы **“Японы империалист намын хөл дор гишгэгдсэн солонгосчууд”** нэртэй товхимлоор эхэлжээ.¹¹ Түүнд: солонгосчууд АНУ, Өрнөдийн орнуудаас ямарч туслалцаа авч чадахгүй болсон ба тэдний цорын ганц найдвар нь большевик чиг шугамыг эзэмшин хувьсгал хийх явдал гэж дурдаад солонгосчууд өөрийн хойг дээрээ хувьсгал гаргах, хувьсгалт үйл ажиллагаагаа явуулахад ЗОУ туслах ба хамтран ажиллахад бэлэн байгаагаа амласан байна.

Тиймээс ч 1919 оны 3-р сард дэлхий дахинд коммунизмыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор байгуулагдсан Коммунист Интернационалийн (Коминтерн) анхдугаар Конгресст 30 орны төлөөлөгчид оролцсоны дотор Солонгосын төлөөлөгч оролцжээ. 1920 оны 6-р сард болсон Коминтернийн II конгресст 41 орны төлөөлөгчид оролцсоны дотор Шанхай дахь Солонгосын Түр засгийн төлөөлөгч Пак Жинь Сүнх, Хан Хён Гун нар оролцсон байна. 1920 оны 9-р сард Зөвлөлт Азербайжаны нийслэл Бакуд болсон Дорно дахины дарлагдсан ард түмний анхдугаар их хуралд 28 орны 2050 гаруй төлөөлөгчид оролцсоны дотор Солонгосын төлөөлөгчид оролцож байв. Улмаар 1921 оны 6-р сард Москвад хуралдсан Коминтернийн III конгресст Бегзеев (проф. Ж.Цэвээн) тэргүүтэй МАН, Ардын Түр засгийн газрын төлөөлөгчид

¹⁰ газ: *Известия*. 15 августа 1919 г

¹¹ СССР и Корея. (под ред. Б.Д.Пак) М., 1987, с. 69

оролцож хурлын үеэр ЗОУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичерин тэднийг хүлээн авч уулзжээ. Г.В.Чичерин III конгресст оролцсон Солонгосын Түр засгийн төлөөлөгчидтэй мөн уулзаж санал солилцсон байна.¹²

1922 оны 1-р сард Москвад эхэлсэн Алс Дорно дахины хувьсгалт байгууллагуудын их хуралд Шаньхай дахь Солонгосын Түр засгийн төлөөлөгч На Юүн Гюнь, Ёо Үнь Хён, Ким Гюү Шиг нарын хамт Монголоос НТХ-ны гишүүн, ГХЯ-ны эрхэлсэн түшмэл Баатуд овогт А.Данзан, МХЗЭ-ийн ТХ-ны дарга С.Буяннэмэх, орчуулагч Б.Ишдорж нар оролцсон байна. Эдгээр Солонгосын төлөөлөгчид Шаньхайгаас Нийслэл Хүрээгээр дамжин Москвад явсан бөгөөд тэдэнд паспорт шийтгэн олгоход нь А.Данзан тусалж байжээ.¹³ МАХН-ын ТХ-ноос тус Их хуралд илгээсэн бичигт: "... Манай Монгол улсаас Вашингтоны хуралдаанд төлөөлөгч илгээсэн нь үгүй. Харин манай намаас төлөөлөгч хүмүүсийг Москва хотноо явуулж буй ажгуу. Манай Монголын урьд, эдүгээгийн байдал ба улаан Орос лугаа харилцах байдал болбоос манай олон монголчуудыг дэлхий дахины улаан намуудаар найрамдах замд түлхэн олон газрын ард лугаа санааг нэгтгэж хамтран явуулах болговой" гэжээ.¹⁴

Зөвлөлт засгийн газар, Коминтерн Шанхай дахь Солонгосын Түр засгийн газрыг санхүүжүүлэхэд туслаж, дээр дурьдсан элч төлөөлөгчдийн замын болон бусад зардлыг дааж байжээ. Энэхүү тусламжийн нэгэн хэсэг 400 мянган рублийн мөнгөн зоосыг 1920 оны дундуур Москвагаас Хүрээ, Хаалган, Бээжингээр дамжуулан Шанхайд хүргүүлсэн ба энэ ажилд тухайн үед Хүрээнд эмчээр ажиллаж байсан Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөний зүтгэлтэн И Тэ Жүнь доктор, Жу Үн Сүнь хэмээх хүний хамт гар бие оролцсон байна. Сүүлийн үеийн судалгаагаар энэ И Тэ Жүнь эмч 1907-1911 онд Сөүлийн Ёнсей Себранс АУДС-д суралцан төгсч цагийн эрхээр эх нутгаасаа даажин 1914-1921 онд Монголд ажиллаж амьдарч ахуй дор Богд гэгээнтнийг болон монголчуудыг эмчилж байсны учир Эрдэнийн Очир одон, тэргүүн зэргийн түшмэлийн хэргэмээр хөхүүлэн шагнасан нь Богд гэгээний ордныхонтой ойр дотно байсныг харуулж байна.¹⁵

¹² газ: Красный стрелок. 1921.06.07 №105 (563)

¹³ Д.Уламбаяр, Өмнөд Солонгос XXI зууны Япон мөн үү? <Өрнө - Дорно> 1998 он, №1-2

¹⁴ "Уриа" сонин 1922 он, № 9, 10

¹⁵ Пан Пен Рюл, Себранс вун Тугниб үндүн (Себранс ба тусгаар тогтнолын хөдөлгөөн) Ёнсэ үйса хаг (Ёнсей анагаах ухаан) сэтгүүл 2-р боть № 2, 1998.04, Пан Пен Рюл, Т.Лхагваа. Монгол-Солонгосын харилцааны уламжлалыг мөшгөхүй. The Mon-Kor Times, 1999.06.15 №4

Зөвлөлт засгийн газар, Коминтерн 1922 онд Москва хотноо шинээр байгуулагдсан Дорно дахины хөдөлмөрчдийн Коммунист Их Сургуульд (КУТВ) Хятад, Монгол, Солонгос болон бусад газруудаас хувьсгалчдыг олноор нь сургах болсон нь суртал ухуулгын үйл ажиллагааных нь чухал хэсэг байв.

1923 онд Зөвлөлт засгийн газар ЗХУ дахь Солонгосын байгууллагуудад Оросын Алс дорнодын тэнгисийн эргийн бүс нутгийг хамарсан аливаа цэргийн халдлага болох тохиолдолд харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор уг бүс нутагт Солонгосын автономит төрийг байгуулахыг зөвшөөрчээ.

Гэвч Солонгосыг дэмжиж байсан бүх талын туслалцаа, суртал ухуулга ч нэгэн адил В.И.Ленинийг нас барснаас хойш жилийн дараа 1925 оны 1-р сарын 20-нд зарлан тунхагласан ЗХУ, Японы хоорондын харилцааг хэвийн болгох тухай Гэрээ болон конвенцийн дагуу бүрэн зогсчээ.¹⁶ Гэрээ ёсоор өөрийн нутаг дэвсгэр дээр тусгаар тогтнолын төлөө үйл ажиллагаа явуулж буй Японы эсрэг байгууллагуудыг (тухайлбал, Шанхай дахь Солонгосын Түр засгийн газартай төстэй байгууллагуудыг оролцуулаад) байгуулах явдалд саад хийнэ хэмээсэн ЗХУ-ын амлалтын хариуд, Япон нь Цагаан Оросын үлдэгдэл улс төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зогсоохыг зөвшөөрсөн байна. Энэ бол ЗХУ-ын хоёр нүүрт дипломат бодлогын олон жишээнүүдийн нэг нь л юм.

ЗХУ 1924 оны 5-р сарын 31-ний Зөвлөлт-Дундад улсын харилцааг хэвийн болгох Гэрээгээр Монгол улсыг ингэж золиосолж байсан билээ. Эдгээр хоёр хэлэлцээрийг аанай л элчин сайд А.А.Иоффе эхлүүлж Л.Карахан “амжилттай” дуусгаж байсан юм.

ЗХУ Японтой харилцаагаа хэвийн болгосны дараа өөрийн нутаг дэвсгэр дээрх Солонгосын байгууллагуудын удирдагчид, иргэдийг баривчлан Сибирыг цөллөгөнд явуулах болсон байна. Ийнхүү Зөвлөлт, Солонгосын хооронд 1920-иод оны эхэнд хэлэлцэгдэж байсан зорилтууд ЗХУ, Японы хооронд дипломат харилцаа тогтоогдсоноор золиослогджээ. Энэ нь Солонгос дахь Японы эзэн эрхийг (сюзернитет) ЗХУ хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.

¹⁶ СССР и Япония. (под ред. И.А.Латышев) М., 1987, сс. 75-76

V. 1930-иад оны Зүүн хойд Азийн олон улсын харилцаа:

1930-иад онд Зүүн Азийн олон улсын харилцаанд хурдан өөрчлөлт орж, тогтвортой бус үедээ орсон билээ. Үүний үндсэн шалтгаан нь их гүрнүүд бүс нутгийн асуудалд өөрсдийн эрх ашгийн үүднээс хандах болсонд оршиж байв.

Япон нь Вашингтоны системийн хүрээнд үндэсний эрх ашгаа тэлэх бодлогоосоо татгалзаж илт түрэмгийлэх бодлогод шилжсэн нь 1931 онд Манжуурын хэргийг үүсгэж, 1937 онд Хятадтай дайн эхэлснээр тодорхой болов.

Их гүрнүүдтэй улам бүр зөрчилдөх болсон нь Японы бодлогод Солонгосын хойгийн үүрэг ролийг дахин авч үзэх шаардлагатай болохыг харуулав, өөрөөр хэлбэл хойгийн геополитикийн ач холбогдлыг дахин шинээр таних явдал байв.

Солонгосын хойг газар зүйн байрлалаараа Манжуурт хамгийн ойрхон, Манжуурыг авахад Японд хүн хүч, эд материалын тусламж үзүүлэх гол цэг болно гэж үзсэн, өөр нэг чухал хүчин зүйл бол Солонгосын хойг Манжуур болон Японы арлуудыг холбох гүүр болж, хожим Японы стратегийн суурь, эдийн засгийн хүрээ нь болж хөгжинө гэж үзжээ. Гурав дахь хүчин зүйл бол Манжуур дахь Солонгос иргэдийн асуудал юм. Япон улс эдгээр солонгосчуудыг өөрийн эзлэн түрэмгийлэх бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглах болно гэж давхар тооцоолж байв.

1931 оны Манжуурын хэргээс хэдэн сарын өмнө Хятадын Жилин мужийн Мобаошан ууланд Хятад болон Солонгосын тариаланчдын хооронд усны хангамжийн хоолойн талаар маргаан гарчээ. Хятад дахь Солонгос иргэдийг хавчин шахаж байна гэж үзэн Солонгосчуудыг хамгаалж буй нэрийн дор Манжуурт Японы зөвлөхүүд хөндлөнгөөс оролцсон нь энэхүү явдлыг Хятад, Японы хооронд дипломат маргаанд хүргэжээ. Сөргөлдөөний хамгийн ноцтой асуудал нь “Манжуурын солонгосчууд”-ын асуудал байв. Японы Гадаад хэргийн сайд 1930 онд Манжуурт суурьшиж буй нийт нэг сая гаруй солонгосчууд нь Манжуур дахь улс төр, нийгэм, арьсны холбоотой асуудалд хэрэгсэхгүй байх хүчин зүйл биш гэж тодорхойлсон байна.

1939 онд Солонгос дахь Ерөнхий захирагч, генерал Минами Жиро үг хэлэхдээ Манжуурт 1 сая Солонгос өрхийн аж ахуй (5 сая хүн) суурьшуулах зорилго бүхий хэтийн төлөвлөгөөг зарлан тунхаглажээ.

Японы дэслэгч генерал Сато Кюкацу бүр 1931 оны 11-р сард <<Манж, Монголын асуудал ба эх газрын талаархи Манай бодлого>> номондоо:

1. Японы нийслэлийг арлаас эх газар тийш аваачих ёстой ба эхлээд Солонгост, дараа нь Манж ба Монголд шилжүүлж аваачвал зохино;
2. Монголыг эзлэх авах;
3. Солонгос, Манж, Монголыг холбосон шинэ төмөр зам тавьж, цаашдаа энэ төмөр замыг Дорнод Сибирь лүү салбарлан тавих;
4. Өвөр Монголын нутагт чадал ихтэй металлургийн үйлдвэрийг байгалийн баялгийг түшиглэн байгуулах;
5. Газар нутгийг нь эзэмшиж ашиглахын тулд ХАА-д ажиллуулахаар солонгосчуудыг Монгол руу нүүлгэвэл зохино гэжээ.¹⁷

Нөгөө талаар Хятад, Японы эсрэг уур амьсгалыг гүнзгийрүүлэх зорилгоор 1927 оны эхэн үеэс Манжуур дахь Солонгос иргэдийн суурьших асуудлыг хавчиж эхэлсэн ажээ. Энэ асуудлаар АНУ-ын нэгэн илтгэлд солонгосчууд Зүүн Азид Япон, Хятад болон ЗХУ хоорондын тоглох “шатрын хүү” болсон гэж бичжээ.

Ийнхүү Мобаошаны хэрэг Манжуурын хэрэг болсон юм. Зүүн Ази дахь улс төрийн байдалд гарч буй хурдан өөрчлөлттэй уяалдан Солонгосын хойгийн стратегийн үнэ цэнэ улам ч өсч байсан ба хэрэв Манжуурт Японы цэргийн хүч хэрэгтэй бол энэ нь өөрийн арлуудаас татаж байснаас хойг дээрээс гаргасан нь хамаагүй амар бөгөөд хямд болох нь тодорхой байв. Хэдий тийм боловч Солонгосын хойгийн стратегийн бодит ач холбогдол нь Манжуур, Солонгос, Японыг эдийн засгийн болон цэргийн хүрээнд шилжүүлэн нэгтгэхэд Японы бодлогын гол зорилго оршиж байв. 1930 онд Солонгос дахь Ерөнхий захирагч, генерал Югаки Казюшиге (1931.07-1936.07) болон түүний залгамж халааг авсан генерал Минами Жиро нар (1936.08-1942.05) эл бодлогыг хэрэгжүүлэхийг ихээхэн чармайж байлаа. Дайлянь (Дайрен: байршлын хувьд Манжуурын хамгийн чухал боомт) Шимоносекийн хооронд дахь зай нь 615 миль байдаг бөгөөд Дайлянь болон Нагасаки хоорондын зай 563 миль байдаг байна. Хэдий тийм боловч Дорнод тэнгисийн дагуу (Япон тэнгис) Цуругагаас хөлддөггүй боомт бүхий Чойн Жинь боомт нь Японыг ирээдүйд “Умард Манжуур болон Монголд нэвтрэх гол хаалга” болгож байсан юм. Нажины боомт хотын хөгжил болон Хятад хүрэх төмөр зам нь Япон, Манжуур болон Солонгосын умард хэсгийн хоорондын тээврийн замыг богиносгох бөгөөд улмаар олон газруудын худалдааг ч мөн өсгөх учиртай байв. Түүнчлэн Дайлянь болон Японы хоорондох зам дайны үед гадны аюулд өртөгдөхөд Дорнод буюу Япон тэнгисээр дамжин өнгөрөх Нажин ба

¹⁷ Капица М. С., Иваненко В. И. *Дружба, завоеванная в борьбе*. М., 1965, с. 67

Японы хооронд дахь замыг хамгаалахад хялбар байв. АНУ-ын Төрийн Департамент тэмдэглэхдээ: сүүлчийнх нь Японы Аж үйлдвэрийн төвөөс Манжуурын нийслэл Цинжин (одоогийн Чанчүн) хүртэлх хамгийн богино зам байжээ. Манжуур нь Японы ивээлээр “тусгаар тогтносон улс” болсон боловч хэрэг дээрээ Япон улсын хил нь Ялу болон Түмэн голоос Хэйлон болон Уссур мөрөн хүртэл тэлсэн бөгөөд ялангуяа улсаа батлан хамгаалах үүднээс Япон улс Манжууртай нэгэн эвсэл болсон юм. Түүнчлэн Солонгосын хойгийн үүрэг хариуцлага болон түүнийг удирдаж байсан арга барил нь хуучинтайгаа адилгүй. Минамигийн өвөг дээдэс нь үндсэн бодлогоо болгож солонгосчуудын сайн сайхан хөгжил цэцэглэлийг дэмжихийг шаардаж байхад Минамигийн харьцуулалтын бодлого болон Солонгосын хойгийн аж үйлдвэрийн хөгжил нь японы империалист төлөвлөгөөнд хувь нэмэр оруулснаар зайлшгүй томъёологдох болсон юм. Хэрвээ Солонгосын хойгт аж үйлдвэржүүлэхэд ахиц дэвшил гарсан нь Япон улс уг бүс нутаг дахь Их Британи болон бусад их гүрнүүдийн ашиг сонирхолд аюул занал учруулан Манжуур болон Хятадын умард хэсэгт хийх эдийн засгийн довтолгоог улам ширүүсгэж байв. Хожим хойно Сайтогийн хязгаарлагдмал либерал бодлогыг арилгасан бөгөөд солонгосчууд цэргийн дэглэм бүхий колонийн удирдлагын эцсийн “хар үе шат”-д орсон. Ерөнхий засгийн газар олон улсын улс төрийн байдал нь хямралд хүргэж байгаа гэдгийг колони улсууддаа сэрэмжлүүлэн сануулж бүх нийтийн дайчилгааны байгууллагуудыг бэхжүүлэв. Энэхүү дайчилгааны хөдөлгөөн нь Солонгосын нийгмийг бүрэн цэрэгжүүлэх зорилготойгоор бүхий л үе шатанд хэрэгжсэн бөгөөд настайчуудыг хүндлэх, эрүүл ахуйн хангамжийг дээшлүүлэх зэрэг ажиллагаа явуулах замаар нийгмийн хөдөлгөөнд оролцуулан, үндэсний батлан хамгаалах нэрийн дор сөнөөгч онгоц болон агаарын довтолгооноос хамгаалах их бууг худалдан авах, эх орондоо хувь нэмэр оруулан хоол, хүнс, хувцас зэрэг өргөн хэрэглээний зүйлс авах, туулширсан шашин мөргөл ёслолыг зогсоох, архи, тамхийг хориглох, мөн Зүүн Азийн ёс суртахууныг зүй зохистойгоор хангахын тулд ёс суртахууны дахин цэнэглэлт зэргийг баттай хамгаалж байв.

Дээрх нөхцөл байдалд Солонгосын асуудлын талаарх их гүрнүүдийн үнэлгээ нь тодорхой бус байлаа. Тэд Ерөнхий засгийн газрын ивээл дор хэрэгжүүлсэн эдийн засгийн хөгжлийг өмнө хэрэгжүүлсэн шигээ үргэлжлүүлжээ. Өөрөөр хэлбэл, Японы авч явуулж буй бодлогууд нь солонгосчуудыг дарлан мөлжих зорилготой биш гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Их гүрнүүд Чусонь гүрний сүүлийн жилүүдийн авилгал болон ёс суртахууны завхарлаас эрс өөрчлөлтөд орсныг

үгүйсгэхийн аргагүй баримтуудын тоон өсөлтийг авч хэлэлцжээ. Тэд үнэн хэрэгтээ Солонгос 1935 онд (Япон засаг захиргаатай болсны 25 жилийн ой) хуучны нүүдэлчин маягийн вант улсаас цоо шинэ нийгэмд шилжсэн бөгөөд ингэснээр зам харилцаа, төмөр зам, цахилгаан мэдээ, эмнэлэг болон сургуулиуд зэрэг орчин үеийн соёл иргэншлийн ашиг тусыг төрийн чиглэлийг үл харгалзан 700000 солонгосчууд “гайхамшигт дэвшлийг” харуулсан боловсролын үр шимийг хүртсэн гэх баримт нь уг үзлийн цөм байсан юм. Вильям Ройдс хүртэл бичихдээ: Солонгосын хойг бүхэлдээ дэг журамтай хэв маягаар ер бусын дэвшилд хүрсэн замыг туулсан хэмээсэн бөгөөд тэрээр Зүүн хойд Азид 20 гаруй жил ажиллаж Их Британийн Ерөнхий консул ба Гуравдугаар сарын нэгний хөдөлгөөний үеэр Ерөнхий засгийн газрын бодлогуудыг ихээхэн шүүмжилж байсан нэгэн юм. Гэсэн хэдий ч энэхүү санал шүүмжлэл нь бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байсан билээ. Өөрөөр хэлбэл түүний үзэл санаагаар бол “хэмжээгүй эрхт засаглал” гол илэрхийлэл нь болох байжээ. Их гүрнүүдийн үзэж байснаар колоничлогдсон Солонгос дахь “хэмжээгүй эрхт засаглал” нь хямралд оруулаагүй, учир нь Чусоний эзэнт гүрний үеэс эхлэн ард түмэн улс төрийн эрх чөлөөг эдлээгүй ажээ. Үүний зэрэгцээ Солонгосын эсэргүүцлийг бүрэн дарж чадсан бөгөөд ингэснээр ихэнх солонгосчуудыг “хувь заяатайгаа эвлэрэхэд” хүргэсэн юм. Хэдийгээр Япончууд Солонгосын эсэргүүцлийг дарж чадсан боловч хоёр улсын хоорондох хурцадмал байдлыг ямар ч аргаар намжааж чадаагүй бөгөөд 1930 оны Солонгосын эсэргүүцлийн төлөвлөгөө нь Японы түрэмгий бодлоготой зөвшилцөлд хүргэж чадаагүй билээ.

VI. Дэлхийн II дайны сүүлчийн улирал ба Солонгосын асуудлаарх Холбоотон гүрнүүдийн шийдвэр:

Дэлхийн II дайны жилүүдэд Холбоотон гүрнүүдийн хооронд Зүүн Ази-Номхон далайн сав дагуух Японы дайны ажиллагаатай холбоотой асуудлаар нижгээд удаагийн бага хурал болжээ. Тухайлбал: 1941 оны 8-р сард Жорж мужид болсон АНУ, Английн тэргүүн нарын Атлантын бага хурлыг хэлэх хэрэгтэй. Бага хурал Японд нефть, нефтийн бүтээгдэхүүн, стратегийн зориулалттай түүхий эд, төмрийн хүдэр, хаягдал нийлүүлэхэд хориг тавих асуудал хэлэлцжээ.

Бага хурлаас гаргасан Атлантын Хартид тэмдэглэхдээ: Бүх ард түмэн өөртөө засан тогтнох эрхтэй, тэдний чөлөөтэй сонгох, тусгаар тогтнох эрхээ сэргээх, эрхийг хүндэтгэх, түүнийг хүчээр хэрэгжүүлэх, ард түмнүүдийн хүсэл эрмэлзлэлээс гадуур

нутаг дэвсгэрийг хүчээр өөрчлөх ёсгүй хэмээн тунхаглажээ. Энэ үндсэн дээр АНУ, Англи хоёр улс Хятад дахь дотоодын хуульд үл захирагдах (экстерриториаль) эрхээсээ татгалзаж байгаагаа албан ёсоор мэдэгджээ. Энэ асуудлаар сүүлд 1943 оны 1-р сарын 11-нд АНУ-Хятад, Англи-Хятадын хооронд 5 зүйлт хэлэлцээрт Вашингтон хотноо гарын үсэг зуржээ.

1941 оны 9-р сард Европ дахь дайны асуудлаар гурван гүрний (АНУ, Англи, ЗХУ) сайд нарын Москвагийн бага хурал болсон байна. Удалгүй 1942 оны 1-р сарын 1-нд болсон Бага хурлын төгсгөлд “Бүх нийтийн аюулгүй байдлын тухай” Нэгдсэн Үндэстнүүдийн Вашингтоны Тунхаглалд 26 улс гарын үсэг зуржээ.

1943 оны туршид Тегераны гурван гүрний тэргүүн нарын бага хурлыг эс оролцуулаад Зүүн Ази-Номхон далай дахь Японы эсрэг дайны ажиллагааны талаар 1943 оны 1-р сард Касабланка (Марокка), 1943 оны 8-р сард Квебек (Канад) болон 1943 оны 11-р сард Кайрт (Египет) Дундад Иргэн Улсын ерөнхийлөгч Чан Кайши оролцсон Гурван гүрний тэргүүн нарын бага хурал тус тус болсон байна.¹⁸

Энэ хооронд 1943 оны 10-р сард АНУ, Англи, ЗХУ-ын ГХ-ийн сайд нар оролцсон Москвагийн бага хурал Вашингтоны тунхаглалыг бүрэн дэмжиж энх тайвныг эрхэмлэдэг бүх улсын тэгш, бүрэн эрхэд үндэслэсэн дэлхийн шинэ байгууллага буй болгох шаардлагатайг цохон тэмдэглэсэн юм. Хятад улс энэ тунхаглалд элчин сайдын хэмжээнд гарын үсэг зуржээ.

Дэлхийд II дайны жилүүдэд Солонгосын асуудлыг тухайлан анх 1943 оны 11-р сарын 22-26-нд болсон АНУ, Англи, Хятадын тэргүүн нарын Кайрын бага хурлаар авч хэлэлцжээ. Энэ хурлыг А+В+С (America, Britain, China) хэмээн нэрлэж байжээ. 1943 оны 12-р сарын 1-нд нийтлэгдсэн Кайрын тунхаглалд заахдаа: “... 1914 оны Дэлхийн I дайнаас эхэлж түрэмгийлэн эзэлсэн Номхон далайн бүх арлуудаас гадна Манжуур, Формоз, Пескадерын арлуудыг оролцуулаад хятадуудаас зүгээр булаан авсан бүх нутаг дэвсгэрээс Японыг үлдэн хөөж Бүгд Найрамдах Хятад Улсыг сэргээн тогтооно... Дээр дурдсан гурван гүрэн Солонгосын ард түмэн боолчлогдон буйг анхааралдаа авч Солонгос нь цаг нь болохоор (in due course) эрх чөлөө, тусгаар тогтнолоо олох ёстой гэдэгт шийдвэр төгс байна... Энэхүү эрхэм зорилгыг өвөрлөн Холбоотон гурван улс Японтой дайны байдалд буй Нэгдсэн Үндэстнүүдтэй

¹⁸ В.И.Израэли. *Дипломатия в годы войны (1941-1945)* М., 1986, с. 128, 189, 212

тохиролцсон ёсоор Японыг үг дуугүй бууж өгөх явдлыг зайлшгүй хангах хүртэл хүнд бөгөөд урт хугацааны үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болно” гэжээ.¹⁹

Дэлхийн II дайны сүүлчийн улирал 1945 оны 2-р сард дайны дараа дэлхий дахины бодлогод чухал нөлөө үзүүлсэн Ялтын бага хурлаар холбоотон АНУ, Англи, ЗХУ-ын тэргүүн нар Кайрын тунхаглалыг хэрэгжүүлэх шийдвэр төгс байгаагаа нотолсон байна. Уг хурлаар ЗХУ Европт дайн дууссаны дараа 3 сарын дотор Японы эсрэг дайнд тодорхой болзолтойгоор оролцохоор болсон билээ.

1945 оны 7-р сард Холбоотон гурван гүрэн АНУ, Англи, ЗХУ-ын удирдлага Берлин хотын ойролцоох Потсдамд хуралдсан юм. Бага хурлаас гаргасан Потсдамын тунхаглалд: “...Кайрын тунхаглалыг хэрэгжүүлсэн нөхцөлд Японы сувернитетийг Хоншю, Хоккайдо, Кюшю, Шикоку арлуудаар хязгаарлаж... дайны дараа Японы ард түмэн ардчилсан замаар сэргэн хөгжих ёстой. Тэнд үг хэлэх, шүтэн бишрэх, чөлөөтэй сэтгэх, хүний эрхийг хүндэтгэнэ” гэж²⁰ заасан байна. Тийнхүү 1945 оны 9-р сарын 2-нд Токиогийн буланд Америкийн цэргийн “Миссиру” хөлөг онгоцон дээр Япон улс үг дуугүй бууж өгөх баримт бичигт гарын үсэг зурснаар Алс дорнод, Номхон далайд дайны ажиллагаа дууссан билээ.

Author describes in his article situation around Korean peninsula, in particular, March first movement, temporary austed Government in Shanhai, hypocritical policy of the Soviets towards Korea also politics of the Great powers in 1930-40-ies..

¹⁹ Г.В.Ефимов, А.М.Дубинский. *Международные отношения на Дальнем Востоке. кн: II, 1917-1945 гг.* М., 1973, с. 209

²⁰ *Международные отношения на Дальнем Востоке. (1870-1945 гг.) под ред. Е.М.Жукова. М., 1951, с. 604*